



184

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2014 оны 11 сарын 14 өдөр


Дугаар 259

Мандалговь

Хөрөнгө худалдах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 2.1.7, 5.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Дэлгэрхангай сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 70'324'800 /далан сая гурван зуун хорин дөрвөн мянга найман зуу/ төгрөгийн анхны өртөгтэй, элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнээ нөхсөн тэжээлийн фондын 2 агуулахыг актлан худалдахыг зөвшөөрсүгэй.
2. 1-р агуулахын худалдах үнийн доод хязгаарыг 10'000'000 /арван сая/ төгрөг, 2-р агуулахын худалдах үнийн доод хязгаарыг 6'000'000 /зургаан сая/ төгрөгөөр тогтоон нийтийн дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн албаны дарга П. Очирбатад үүрэг болгосугай.
3. Худалдсан эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу данс бүртгэлээс хасахыг Дэлгэрхангай сумын Засаг даргын тамгын газрын дарга Н.Дашцэрэнд даалгасугай.



0100553